



АЖЛЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2025 ОН

НЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

1. Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг, хөнгөлөлт, буцалтгүй тусламж олгох

1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолын хавсралт "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, эргэн төлүүлэх журам"-д заасны дагуу зорилтот бүлгийн суралцагч

- бүтэн өнчин,
- нэг гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн хагас өнчин суралцагч,
- эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй өрхийн нэг суралцагч,
- хөгжлийн бэрхшээлтэй суралцагч,
- хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагч
- цаатан, тува, урианхай үндэстний өрхийн нэг суралцагч,
- нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дотоодын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр зэрэг суралцагч,
- "Монголын сайхан бичигтэн" уралдааны эхний гурван байрт шалгарсан суралцагчид буцалтгүй тусламж олгосон.

Дээрх суралцагчид 2024-2025 оны хичээлийн жилийн II улиралд /хавар/ 2309 суралцагчид 5.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон, 2025-2026 оны хичээлийн жилийн I улиралд /намар/ 2309 суралцагчид 5.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталгаажсан.

2. 2025 оны Засгийн газрын 215 дугаар тогтоол, түүний хавсралт журмын 5.3.2 буюу тэргүүлэх мэргэжлээр суралцагчдад журмын 5.13 заасны дагуу сургалтын төлбөрийн тэтгэлэг (Засгийн газрын тэтгэлэг) олгосон.

2024-2025 оны хичээлийн жилийн II улиралд /хавар/ 888 суралцагчид 2.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. 2025-2026 оны хичээлийн жилийн I улиралд /намар/ 1006 суралцагчид 2.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталгаажсан байна.

3. Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадаас Монгол улсад суралцаж байгаа суралцагчдад сургалтын төлбөрийн болон дотуур байрны зардлыг тухайн сургалтын байгууллагын нэхэмжилсэн дүнгээр, хүнсний зардлыг Үндэсний статистикийн хорооноос тогтоосон тухайн жилийн хүн амын амьжиргааны доод түвшнээр тооцож олгосон.

Тус хөтөлбөрийн дагуу 2024-2025 оны хичээлийн жилийн II улиралд /хавар/ 223 суралцагчид 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт, 2025-2026 оны хичээлийн жилийн I улиралд /намар/ 239 суралцагчид 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус олгосон. Нэмэлтээр 8 суралцагчид 38.4 сая/төг-ийн санхүүжилт олгохоор баталгаажсан.

4. Зарим эрэлттэй мэргэжлээр (сувилахуй, нийгмийн ажилтан, номын сан, хоол зүй, шим судлал, мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэл бусад мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн багшийн хөтөлбөрөөр суралцагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, сэтгэл зүйч, арга зүйч) суралцагчдад дагуу тэтгэлэг олгосон.

Дээрх мэргэжлүүдээр суралцагчдад 2024-2025 оны хичээлийн жилийн II улиралд /хавар/ нийт 2284 суралцагчид 3.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон, 2025-2026 оны хичээлийн жилийн I улиралд /намар/ 2369 суралцагчид 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталгаажсан.

5. 2025 оны Засгийн газрын 215 дугаар тогтоол, түүний хавсралт журмын 9.1-д заасны дагуу орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт үзүүлнэ.

Дээрх заалтын дагуу 2024-2025 оны хичээлийн жилийн II улиралд /хавар/ санхүүжилт олгоогүй бол 2025-2026 оны хичээлийн жилийн I улиралд /намар/ 1184 суралцагчид 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталгаажсан байна.

6. Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоол, түүний хавсралт журмын 10.7-д заасны дагуу журмын 10.2-т заасан суралцагчид сургалтын төлбөрийн хэмжээгээр, эргэн төлөх нөхцөлтэй зээл олгосон. 2024-2025 оны хичээлийн жилийн II улиралд /хавар/ 845 суралцагчид 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон, 2025-2026 оны хичээлийн жилийн I улиралд /намар/ 1158 суралцагчид 3.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталгаажсан.

II. Багш суралцагчид төрөөс дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа-төрөөс дэмжлэг үзүүлэх

1.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоол, түүний хавсралт журмын 1.1-д заасны дагуу

- багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч,
- багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр суралцагч,
- багш мэргэжлээр дадлагажигч, орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш
- багш, ажилтны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах нэг хүүхдэд дэмжлэг үзүүлнэ.
- Мөн төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр (өндөр оноо) суралцагчийн тэтгэлгийг үргэлжлүүлэн олгосон.

Дээрх заалтын дагуу 2024-2025 оны хичээлийн жилийн II улиралд /хавар/ 5211 суралцагчид 10.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бол 2025-2026 оны хичээлийн жилийн I улиралд /намар/ 7854 суралцагчид 18.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталгаажсан.

Гэрээ хийх, сунгах:

- Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагын давхардсан тоогоор 14,860 суралцагчид санхүүжилт олгосон бөгөөд суралцагч, сургалтын байгууллагатай хамтарсан 44,580 ш гэрээг шинээр болон шинэчлэн хийж баталгаажуулж байна.
- “Багш” хөтөлбөрөөр давхардсан тоогоор 13065 суралцагчид 28.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд суралцагч, сургалтын байгууллагатай хамтарсан 39195 ш гэрээг шинээр болон шинэчлэн хийж баталгаажуулж байна.

III. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг, хөнгөлөлт, буцалтгүй тусламж олгох

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолын хавсралт "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, эргэн төлүүлэх журам"-д заасны дагуу:

- *Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг:* 2025 оны байдлаар 1267 суралцагчид 50.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.
- *Дэлхийн шилдэг сургалтын байгууллагад суралцагчийн сургалтын зээл:* Нийт 166 суралцагчид 13.96 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.
- *Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг:* 2025 оны байдлаар 42 суралцагчид 4.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.
- *Засгийн газар хоорондын тэтгэлэг:* 2025 оны байдлаар 108 суралцагчид 6.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.
- *Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн буцалтгүй тусламж:* 2025 оны байдлаар 6 суралцагчид 906.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

IV. Зээлийн эргэн төлөлт

- *Дотоодын хөтөлбөрүүдийн эргэн төлөлт:* Давхардсан тоогоор 47004 суралцагчийн 14.4 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.
- *Гадаад сургалтын зээлийн эргэн төлөлт:* 64 суралцагчийн 3.3 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

I. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах

Байгууллагын хэмжээнд хууль тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Энэ хүрээнд:

1. Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлах тухай” А/331 дугаар тушаалаар Ажлын албаны бүтцийг 32 орон тоотой байхаар баталсан.
2. Ажлын албаны бүтцийн зохион байгуулалт, шинэчлэлтийг Ажлын албаны даргын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/96 дугаар тушаалаар, албан тушаал, ажлын байрны нэр, ангилал, зэрэглэлийг 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/97 дугаар тушаалаар тус тус батлан, бүтэц шинэчлэгдсэн.

2025 оны жилийн эцсийн байдлаар 28 албан хаагчтай (хүүхэд асрах чөлөөтэй албан хаагч-2), хүний нөөцийн бүрдүүлэлт 87.5%, шилжилт хөдөлгөөний байдлыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулан авч үзвэл 45.8%-иар буурч, тогтворжсон.

Нийт албан хаагч: -доктор-4 (14.3%), магистр-14 (50%), бакалавр-9 (32.1%), бүрэн дунд-1 (3.6%), магистр, докторын эзлэх хувь 64.3% байна.

Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн: Ажилд шинээр томилогдсон-9, ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн-7, ажил олгогчийн санаачлагаар ажлаас чөлөөлөгдсөн-4 албан хаагч байна.

Үйл ажиллагаандаа дараах хууль, тогтоомжийг тусгайлан мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолын хавсралт “Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”
- Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолын хавсралт “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 72 дугаар тогтоолын хавсралт “Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”
- БШУС-ын 2024 оны А/256 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын зээлийн сангийн ажлын албаны ажиллах журам”
- Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын 2025 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”
- Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын 2025 оны А/153 дугаар тушаалаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”

Мөн Ажлын албаны даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

1. Хамт олны сургалт-5

- 04 дүгээр сарын 24-ны өдөр "Жавзандамба хутагт" төвийн багш, гавж Д.Нямсамбуу "Санамсрын бясалгал, сэтгэлийн эрүүл мэнд" сэдэвт сургалт, албан хаагчдын ирц 88,8%,
- Эко сургалт-2 удаа, ирц 92,4%,
- И-Монгол академиас Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн /<https://erp.e-mongolia.mn/> сургалт, ирц 92%,
- 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Авлигатай тэмцэх газраас цахимаар зохион байгуулсан "Авлигаас урьдчилан сэргийлэх нь, анхаарах асуудлууд" сэдэвт сургалт, ирц 92.3%.

2. Ганцаарчилсан сургалт-5, хамрагдсан албан хаагч-8

- Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн С.Ариунтуяа "Архив, албан хэрэг хөтлөлтийн чадавхжуулах" сургалт 10 өдөр;

- 2.Ахлах мэргэжилтэн Д.Доржсүрэн, Ч.Гэрэлчимэг "Монгол дохионы хэлний анхан шатны мэдлэг, чадвар олгох" сургалт 5 өдөр;
 - 3. Ажлын албаны дарга О.Сийлэгмаа, ахлах мэргэжилтэн У.Цэцэгдэмбэрэл "Дэлхийн хүн" уулзалт хэлэлцүүлэг 1 өдөр (Хөвсгөл аймаг);
 - 4. СЗТХ-ийн дарга Б.Гантөмөр "Боловсролын зээлийн сангийн журмын шинэчлэл" 2 өдөр;
 - 5. Цахим хөгжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн Р.Баасанцэрэн "ERP цахим систем" 1 өдөр.
 -
3. Бүлэг сургалт-5, хамрагдсан албан хаагч-15 байна.

II. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Ажлын албаны даргын А/01 дугаар тушаалаар албан хаагчдын цалин хөлс, нэмэгдлийг хэмжээг шинэчлэн тогтоож, мөрдөн, хэрэгжүүлж ажилласан.

Цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг шинэчлэн батлагдсанаар албан хаагчдын цалин хөлс өмнөх онтой харьцуулахад 13,3 хувиар өссөн байна.

Боловсролын зээлийн сангийн албан хаагчдаас 2025 онд эрхэлсэн ажилдаа идэвхи зүтгэл гарган ажиллаж байгаа 2 албан хаагчийг Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор, 4 албан хаагчийг "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар, 1 албан хаагчийг Сангийн яамны "Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр, 1 албан хаагчийг Боловсролын яамны "Боловсролын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр, 1 албан хаагчийг Боловсролын яамны "Жуух бичиг"-ээр, 1 албан хаагчийг Цахим хөгжил инноваци, харилцаа холбооны яамны "Жуух бичиг"-ээр тус тус шагналд нэр дэвшүүлэн, тодорхойлж шагнагдсан байна.

Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолтой холбоотой Боловсролын зээлийн сангийн 2025 оны А/01 тушаалын дагуу сар бүрийн 10,25-ны өдөр 28 албан хаагч нарын цалинг тооцоолж, 1,043,4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 3 албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй байна.

10 албан хаагчийн 8.4 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг тооцоолж, нийгмийн даатгалын систем рүү илгээсэн.

Системээр баталгаажсан эмнэлгийн хуудсыг Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалд цаасаар баталгаажуулан, нийгмийн даатгалаас орж ирсэн орлогыг хуваарилуулан хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг албан хаагч нарын дансанд шилжүүлсэн.

Төрийн албаны цалингийн нэгдсэн системээс цалингийн мэдээллийг нийгмийн даатгалын системд албан хаагч нэг бүрчлэн шивж нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд илгээж байна.

Нийгмийн даатгалаар цахимаар баталгаажсан НД-7, НД-8 тайланг дахин цаасаар баталгаажуулан сар бүр Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газарт очиж баталгаажуулан, ажилласан.

III. Өргөдөл, гомдол, албан бичгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх

Өргөдөл гомдол: Иргэдээс ирүүлсэн 729 өргөдлийг цахим файл үүсгэж, ABLE болон ERP системд тухай бүр бүртгэн, ажлын албаны даргад танилцуулж, холбогдох нэгж, нэгжийн дарга, мэргэжилтэнд шилжүүлэн, шийдвэрлэн, хариу өгч ажилласан. Үүнд: Шийдвэрлэсэн өргөдөл гомдол-716, хяналтад байгаа 13, Хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь-98.2 %.

Ирсэн албан бичиг: Гадны байгууллагаас ирсэн 498 албан бичгийг сканердан цахим файл үүсгэж, ABLE болон ERP системд бүртгэн Ажлын албаны даргад танилцуулсан. Ажлын албаны дарга ирсэн бичгийг холбогдох албан хаагчид шилжүүлэн, шийдвэрлэн, хариу өгч ажилласан байна. Үүнээс 332 албан бичиг нь хариугүй, 166 албан бичиг нь хариутай, хариутай бичгээс шийдвэрлэсэн 141, хяналтад байгаа 25, хугацаа хэтэрсэн албан бичиг байхгүй байна.

Явуулсан албан бичиг: Байгууллага болон иргэдэд нийт 1226 албан бичгийг стандартын дагуу хэвлэмэл хуудсанд буулган, дугаарлаж, нэгдсэн бүртгэлд бүртгэн, ABLE болон ERP системд оруулж, хүргүүлэн ажилласан.

Цахим шуудан: Иргэд, байгууллагаас ирүүлсэн 139+1644 (гадаадад суралцагчаас) цахим шууданг ажлын албаны дарга болон холбогдох нэгж, нэгжийн дарга, мэргэжилтэнд и-мэйлээр илгээж танилцуулсан.

Тушаал: Ажлын албаны даргын А тушаал 180, Б тушаал 92, хэвлэмэл хуудсанд стандартын дагуу буулган цахим файл үүсгэн хадгалсан.

IV. Архив, албан хэрэг хөтлөлтийн санг баяжуулаж, цаасан болон цахим бүртгэлийг сайжруулж ажиллах

Ажлын албаны даргын А/116 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан, Архивын албан хэрэг хөтлөлтийн журмын хэрэгжилтийг хангах, Архивын ерөнхий газрын албан шаардлагыг биелүүлэх, зөрчлийг арилгах, 2024 оны Боловсролын зээлийн сантай байгуулсан 02/1124 дугаар гэрээний үүргийг хангуулах ажлыг хүрээнд дараах үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан. Үүнд:

- 2022-2024 оны байгууллагын "ХХНЖ"-ыг харьцуулж, баримт бичгүүдийг ангилах,
- 2022 оноос хойшхи архивт өгөөгүй баримтуудыг "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын дагуу хүлээн авч, архивлах,
- Архивын баримтыг нэр төрөл, зохион байгуулалт, ач холбогдол зэрэг үндсэн шинжээр ангилан төрөлжүүлэх,
- Баримтын хадгалах хугацааг зөв тогтоосон эсэх, байнга хадгалах, түр хадгалах баримтыг тус тусад нь ангилан төрөлжүүлэх,
- Байнга, түр хадгалах баримт холилдсон бол баримтын хадгалах хугацааг архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны

үлгэрчилсэн болон салбарын жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тогтоож, тус тусад нь хэрэг бүрдүүлэх,

- Архивд хүлээн авсан баримтыг бүртгэх, батлагдсан загварын дагуу үйлдэх, хадгаламжийн нэгж дансны баталгааны хуудастай, данс бүртгэл үйлдэх,
- Хадгаламжийн нэгжийн нүүр, баталгааны хуудас бичилт хийх, ашиглалтын хуудас хөтлөх, А5 хэвлэмэл хуудаст үйлдсэн баримтыг стандартын дагуу үдэх, хадгаламжийн нэгжид тавигдах шаардлагыг хангах,

Архивын баримт бичгийг хадгалах хугацаагаар нь:

- Байнга хадгалах баримтын данс 1994-2023 оны 191 хн
- Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл 1993-2023 оны 621 хн
- 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл 1994-2023 оны 315 хн
- Устгах баримтын жагсаалт 2006-2021 оны 62 хэрэг ангилан бүртгэсэн.

АХН-ээс 516 баримт албан хаагчдад хүлээлгэн өгч, 490 баримт буцаан хүлээн авсан, 26 баримт албан хаагчид дээр ашиглагдаж байна. Архивын нийт 1764 хадгаламжийн нэгжээс хадгалах 196 ХН, Түр хадгалах 633 ХН, 70 жил хадгалах 873 ХН, Устгах 62 ХН байна.

V. Авлигын эрсдэл, хүнд суртлаас урьдчилан сэргийлэх

Авлигатай тэмцэх газраас Авлигын талаар хэрхэн мэдээлэх, Авлигын эсрэг хориглолт, хязгаарлалтуудын талаар зурагт хуудаснууд авч, байгууллагын үүдний иргэдийн үйлчлүүлэх хэсэгт байрлах ширээн дээр байршуулж, танилцуулга хийсэн.

Ажлын байрны мэдээллийн дэлгэц дээр "Авлига, ашиг сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх" талаар Авлигатай тэмцэх, газраас бэлтгэсэн видео сургалтыг байршуулсан.

Боловсролын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргаас 2025.11.05-ны өдөр өгсөн үүргийн дагуу Боловсролын зээлийн сангийн цахим хуудасны нүүрэнд "Авлигатай тэмцье" уриа үгийг Авлигыг мэдээлэх 110 дугаарын хамт байршуулсан.

Боловсролын зээлийн сангийн цахим хуудасны "Авлигын эсрэг үйл ажиллагаа" буланд "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г тус тус байршуулсан.

Боловсролын яамны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Боловсролын зээлийн сангийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 16:00 цагт Авлигатай тэмцэх газраас цахимаар зохион байгуулсан "Авлигаас урьдчилан сэргийлэх нь, анхаарах асуудлууд" сэдэвт сургалтад нийт албан хаагчид идэвхитэй оролцсон.

Ил тод байдал, хариуцлагын стандартыг хангахын тулд "Ёс зүйн дэд хороо" гэсэн шинэ цэсийг бий болгож, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, тус хороотой холбоотой тушаал, тогтоол, журам болон 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд нээлттэй байршуулсан.

Тайлан, өргөдөл гомдлын ангиллыг шинэчлэн үр ашигтай болгож, 2017–2024 оны гүйцэтгэлийн аудитын тайлан болон 2025 оны 1–3 дугаар улирлын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг олон нийтэд нээлттэй байршуулсан.

Байгууллагын утсаар холбогдох үед иргэдэд өгөгдөх автомат мэдээллийг хэрэглэгчдэд илүү ойлгомжтой, ээлтэй байдлаар шинэчлэн боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэн ажиллаж, төрийн үйлчилгээг шуурхай түгээсэн.

VI. Хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хугацаанд нь программд оруулж, тайлагнах

Салбарын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан <https://meds.igovernment.mn> цахим системд:

- салбарын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт (Сайдын шуурхай 14 хоногийн мэдээ),
- байгууллагын сарын ажлын тайлан,
- байгууллагын улирлын тайлан,
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн ХБТББ хэрэгжилт тайлан, мэдээ,

Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим сан => <https://plan.igovernment.mn> цахим системд:

- байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт (хагас жил, жилийн эцэс) зэргийг заасан хугацаанд тайлагнаж ажилласан. Үүнд: 7 хоног тайлан-30 удаа (2025 оны 10 сараас 14 хоногт 1 удаа мэдээ хүргүүлдэг болсон.)
- Сарын тайлан-12 удаа (баталгаажсан-9, хугацаа хоцорч баталгаажсан-2025. 02, 04, 05 сар)
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт (2025 онд 8 удаагийн хэрэгжилтийг тухайн үед оруулсан албан даалгаврын хүрээнд тайлагнасан)
- Жилийн тайлан-1 (2025 оны 8 зорилт, 31 арга хэмжээний хүрээнд тайлагнасан).

Салбарын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд (<https://meds.igovernment.mn/law>) тайлагнасан байдал:

- Боловсролын яамны хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд <https://meds.igovernment.mn/law/> 2025 оны 10, 11, 12 сарын ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийг оруулж, Ажлын албаны дарга баталгаажуулан, илгээсэн.
- Салбарын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт (Сайдын шуурхай 14 хоногийн мэдээ)-6 удаа,
- Байгууллагын сарын ажлын тайлан-3 удаа, улирлын тайлан-1 удаа,
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт-7 зорилтын хүрээнд 33 арга хэмжээ,
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн ХБТББ хэрэгжилт-2 зорилтын хүрээнд 2 арга хэмжээ,

- Сургалт ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр-2 зорилт 7 арга хэмжээ,
- Ил тод байдлын шалгуур үзүүлэлт- 5 зорилт 46 арга хэмжээг

тус тус хугацаанд тайлагнаж ажилласан.

Салбарын Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим сан => (<https://plan.igovernment.mn>) тайлагнасан байдал:

1. Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим сан => <https://plan.igovernment.mn> цахим системд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт (жилийн эцэс)-ийг 8 зорилтын хүрээнд 30 арга хэмжээгээр заасан хугацаанд бүрэн тайлагнасан.

VII. Хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах

Боловсролын зээлийн сангаас олгодог тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл болон бусад санхүүгийн дэмжлэгийг шударга, нээлттэй, стандартчлагдсан байдлаар зохион байгуулах зорилгоор 2025 онд “Сонгон шалгаруулах мэдээллийн систем”-ийг анх удаа нэвтрүүлэн ашиглаж эхэллээ.

Өмнө нь сонгон шалгаруулалт нэгдсэн цахим системгүй, бичиг мэдээллийн алдаа, давхардал, хугацааны алдагдал, ил тод бус орчин үүсгэдэг байсан бол шинэ систем нэвтэрснээр бүртгэл, материал шалгалт, үнэлгээ, оноо тооцох, дүгнэлт гаргах шат дамжлага бүрэн автоматжсан, ил тод цахим орчин бүрдсэн.

Сонгон шалгаруулах үйл ажиллагааг хөндлөнгийн оролцоо багатайгаар цахимаар зохион байгуулах ажлын хүрээнд сонгон шалгаруулах процесст бизнес анализ хийж, процессын зураглал гарган, Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулагдсан Боловсролын зээлийн сангийн цахим мэдээллийн системийн архитектурыг боловсруулах ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн.

Хэлэлцүүлсэн процессын зураглал дээр үндэслэн ажлын даалгаврыг боловсруулж, Боловсролын яам 2025 оны 02 дугаар сарын 14–24-ний өдрүүдэд тендер зарлаж, системийг хөгжүүлэх компанийг сонгон шалгаруулсан.

Хөгжүүлэгч компаниар “Дижитал Кредит” ХХК шалгарч, тендерийн үнэлгээний хороо, Боловсролын зээлийн сангийн хамтарсан уулзалтыг зохион байгуулж сонгон шалгаруулалтын процессын ажлын явц, нүүр хуудаст орох мэдээлэл, сонгон шалгаруулах ажлын хэсгийн үйл ажиллагааны процессын зураглал, шаардлагатай серверийн хүчин чадал, систем хөгжүүлэлтийн явц, тулгарч буй хүндрэлүүд, техникийн шийдэл, ашиглах домэйн хаяг, мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалтын талаар хэлэлцэж, шаардлагатай шийдлүүдийг боловсруулсан.

Системийн хөгжүүлэлт нь мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001, хувийн мэдээлэл хамгаалах ISO 27701 стандартуудыг нэвтрүүлсэн байгууллагаар хийгдэж, Secure SDLC аргачлалаар бүх үе шатанд аюулгүй байдлын шаардлагыг тусгасан. SAST, DAST, penetration test зэрэг сорилтуудыг хийж эмзэг байдлыг эрт илрүүлэн

засварласан бөгөөд OWASP Top 10 стандартыг бүрэн хэрэгжүүлсэн нь төрийн мэдээллийн сангийн найдвартай орчныг хангаж байна.

Системийн хөгжүүлэлтэд шаардлагатай серверийн мэдээллийг боловсруулж, серверийн дэд бүтэц Боловсролын мэдээлэл технологийн төвийн дата төвд байрлаж байгаа нь үндэсний аюулгүй байдал, өгөгдлийн хамгаалалт, найдвартай ажиллагааг хангах чухал хүчин зүйл юм. Дата төв нь 24/7 хяналттай, инженерийн багтай, цахилгаан болон хөргөлтийн нөөц системтэй, өргөтгөх боломжтой дэд бүтцийг бүрдүүлсэн.

“ДАН” системийн гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны 2025/437 мөн “ХУР” системийн холболтын гэрээг 2025 оны 05 сарын 19-ний 2025/549 тоотой тус тус байгуулж, ашиглагдах серверийн жагсаалт, шаардлагатай токен, сертификат болон бусад мэдээллийг боловсруулж, Үндэсний дата төвтэй хамтран шийдвэрлэсэн

Иргэд E-Mongolia/ДАН-аар нэвтрэн, мэдээлэл ХУР системээр баталгааждаг тул хуурамч бүртгэл, давхардал үүсэх боломжгүй болж, өгөгдөл дамжих болон хадгалагдах бүх түвшинд шифрлэгдэн хамгаалагддаг. Мөн логжилт, аудит, мониторингийн мэдээлэл SIEM системд төвлөрч write-only хэлбэрээр хадгалагдан, халдлага илрүүлэх автомат механизмууд тогтмол ажиллана.

Системийн үндсэн боломжид цахим бүртгэл, баталгаажуулалт, баримтын цахим хүлээн авалт, автомат үнэлгээний алгоритм, ил тод хяналтын орчин багтах бөгөөд оролцогч өөрийн явцыг бодитоор хянах боломжтой.

Үнэлгээний алгоритм нь хүний оролцоог багасгаж, шударга, хөндлөнгийн нөлөөгүй шалгаруулалтын орчин бүрдүүлсэн. Хэрэглэгчийн интерфэйс нь хөнгөн ажиллагаатай, бүх төрлийн төхөөрөмжөөс ашиглах боломжтой.

2025 оны 05дугаар сарын 23-ны өдөр <https://scholarship.elf.gov.mn> домэйн хаягаар системийг нээж ажиллуулсан. Систем ашиглахтай холбоотой заавар, зөвлөгөөг өгч, систем ашиглах гарын авлага бэлдэж, байршуулсан.

Сонгон шалгаруулалтын үр дүнг <https://scholarship.elf.gov.mn/rlist> хаягаар олон нийтэд ил тод нээлттэй мэдээлсэн. Ийнхүү 2025 оноос эхлэн тэтгэлэг, сургалтын зээл олгох үйл явцыг нэгдсэн, хөндлөнгийн оролцоогүй, ил тод цахим системд төвлөрүүлснээр шударга, баталгаатай сонгон шалгаруулалтын шинэ соёлыг бий болгож, салбарын цахим шилжилтийг нэг шат ахиулсан тогтолцоо бүрдсэн.

VIII. Мэдээллийн системийн хөгжүүлэлт хийх, сайжруулах

Сургалтын хөнгөлөлттэй зээлийн системийн хөгжүүлэлт, сайжруулалтын хүрээнд “Өнө-Тэгш” ХХК-тай 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдөр 25/03 дугаар гэрээг байгуулж, системийн шаардлагатай сайжруулалт, өргөтгөлийн ажлуудыг хамтран гүйцэтгэв.

Гэрээний дагуу оюутны сургалтын зээлийн системд зээлийн шинэ төрөл нэмэх, гадаад валютаар зээл олгох боломжийг бүрдүүлэх, суралцагчийн

баталгаажсан мэдээллийг системд хөрвүүлэн оруулах ажиллагааг хийж хэрэгжүүллээ.

Мөн мэдээлэл нийлүүлэлтийн явцад илэрсэн зөрүүтэй зээлдэгчийн мэдээллийг системээс гарган шалгах, тухайн зээлдэгчийн овог, нэр, регистр, сургууль зэрэг үндсэн мэдээллийг засварлаж дахин илгээх замаар Зээлийн мэдээллийн санд баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн.

Үүнтэй холбоотойгоор эргэн төлөлтийн мэдээллийг системд гараар бүртгэн оруулах, Монголбанкны Зээлийн мэдээллийн системд зээлийн үлдэгдлийг шинэчлэн илгээх, зээлийн эргэн төлөлтийн график үүсгэх боломжийг системд бүрдүүлж өгөв. Ийнхүү зээлийн мэдээллийг нэмэх, засварлах, баталгаажуулах, мэдээллийн урсгалыг сайжруулах зэрэг чиглэлээр бүх ажлыг хөгжүүлэгч компанитай хамтран амжилттай хэрэгжүүллээ.

Буцалтгүй тусламжийн мэдээллийн системийн хөгжүүлэлт сайжруулалтын хүрээнд хөгжүүлэгч “Өнө-Тэгш” ХХК-тай 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр 01/27 дугаар ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, зарим эрэлттэй мэргэжлийн 8 хөтөлбөр, багш болон багш мэргэжлээр суралцагч, мөн багш, ажилтны хүүхдэд үзүүлэх дэмжлэгийн 4 хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг болон бусад нийт 14 хөтөлбөрийн сүүлийн 1–3 жилийн суралцагчдыг системд бүртгэх ажлыг гүйцэтгэсэн.

Үүнээс гадна 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 25/008 дугаар гэрээг байгуулж, буцалтгүй тусламжид хамрагдсан суралцагчдын мэдээллийг боловсруулах, санхүүжилтийн дэлгэрэнгүй болон товч тайлан гаргах зэрэг ажлуудыг хөгжүүлэгч компанитай хамтран хэрэгжүүлэв. Ингэснээр буцалтгүй тусламжийн хөтөлбөрүүдийн мэдээллийн бүртгэл, боловсруулалт, тайлагналын процесс үе шаттайгаар шинэчлэгдэж, системийн өгөгдлийн хүртээмж, ашиглалт, ил тод байдал сайжирсан болно.

IX. Олон нийтэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх

Мэдээлэл хүргэж буй онлайн сувгийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод түгээх зорилгоор иргэдэд мэдээлэл хүргэх сошиал платформуудыг өргөтгөн, YouTube, Twitter, LinkedIn зэрэг шинэ сувгийг нээн ашиглаж эхэлсэн.

Одоогийн байдлаар байгууллагын вэб хуудас, Facebook, YouTube, Twitter, LinkedIn, Instagram зэрэг цахим сувгаар нийт 84 контентыг түгээн, давхардсан тоогоор 3.9 сая орчим иргэнд мэдээлэл хүргэв.


Сошиал сувгуудаар ирүүлсэн иргэдийн асуултад шуурхай хариулах үйлчилгээг үзүүлж, нийт 1,920 иргэнд заавар, зөвлөгөө өгсөн бөгөөд нэг хүнд хариу өгөх дундаж хугацаа 2 минут байлаа. Үүнээс 1,552 иргэн анх удаа мэдээлэл авах зорилгоор холбогдсон бол 368 иргэн дахин лавлагаа хийсэн байна.

Иргэдээс ирж буй асуултыг тогтмол шинжилж, олон давтамжтай асуултын чиглэлээр зориулсан контентуудыг бэлтгэн сошиал сувгуудаар хүргэж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.


Мөн байгууллагад ирж үйлчлүүлж буй иргэдэд мэдээллийг илүү хүртээмжтэй хүргэх зорилгоор хүлээн авах хэсэгт мэдээллийн дэлгэц байршуулж, буцалтгүй тусламж, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээлийн үйлчилгээ, авлигатай тэмцэх чиглэлийн мэдээллийг тогтмол танилцуулж байна.

Иргэдээс ирж буй асуултыг тогтмол шинжилж, олон давтамжтай асуултын чиглэлээр зориулсан контентуудыг бэлтгэн сошиал сувгуудаар хүргэж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Мөн байгууллагад ирж үйлчлүүлж буй иргэдэд мэдээллийг илүү хүртээмжтэй хүргэх зорилгоор хүлээн авах хэсэгт мэдээллийн дэлгэц байршуулж, буцалтгүй тусламж, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээлийн үйлчилгээ, авлигатай тэмцэх чиглэлийн мэдээллийг тогтмол танилцуулж байна.



Зураг 1. Фэйсбүүк хандалтын статистик



Зураг 2. Иргэдэд хариу өгсөн байдал

Х. Мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх

Боловсролын зээлийн сангийн алын албаны “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/153 тоот тушаалаар шинэчлэн батлуулж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөн хэрэгжүүлж эхэлсэн.

Журмын шинэчилсэн найруулгаар ISO/IEC 27001:2022 стандартын шаардлагад нийцүүлэн хүний нөөц, техник тоног төхөөрөмж, сүлжээ, хандалтын удирдлага, серверийн аюулгүй байдал зэрэг үндсэн чиглэлүүдийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын түвшинг сайжруулах боломж бүрдүүлсэн.

Зөрчил илрүүлэх, бүртгэх, хариу арга хэмжээ авах үйл явцыг нарийн тогтоосноор байгууллагын хариу үйлдлийн чадавх дээшилж, эрсдэлийн бууралтад бодитой үр дүн гарсан.

Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн лавлагааг иргэдэд ойроос хүргэх зорилгоор сургалтын зээл авсан иргэдийн төлбөрийн хуваарийг И-Монголиа платформоор авах боломжийг бүрдүүлж, “И-Монгол Академи” УТҮГ-тэй хамтран энэхүү үйлчилгээг хөгжүүлэн нийлүүлэв.

Энэ ажлын хүрээнд хөгжүүлэгч “Өнө-Тэгш” ХХК-тай 2025 оны 25/03 дугаар гэрээг байгуулж, өгөгдөл солилцох болон дамжуулах сервисийг REST/API технологид тулгуурлан, өгөгдлийг JSON форматтайгаар боловсруулах техникийн шийдлийг Үндэсний дата төв болон И-Монгол Академийн холбогдох багуудтай хамтран боловсруулсан.

ХУР системд баталгаажсан мэдээлэл нийлүүлэхийн тулд төрийн мэдээллийн сүлжээнд холбогдох шаардлагатай сервер, сүлжээ, портуудын тохиргоог Боловсролын мэдээлэл технологийн төвтэй хамтран хийж гүйцэтгэн, үйлчилгээний хэвийн ажиллагааг бүрэн хангахаар зохион байгуулан ажилласан.

Иргэн регистрийн дугаар ашиглан мэдээлэл авахад тухайн зээлдэгчийн үндсэн мэдээлэл болон бүх зээлийн жагсаалт харагдаж, жагсаалтаас сонгосон зээлийн эргэн төлөлтийн граfiкийг дэлгэрэнгүйгээр харах боломжийг бүрдүүлсэн.

Үйлчилгээг 2025 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын эхний хагасын байдлаар нийт **19,192** удаагийн лавлагааг иргэд авч ашигласан байна. Энэ нь үйлчилгээний бодит хэрэгцээ өндөр, нэвтрүүлэлт амжилттай байсныг харуулж байна.

Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх ажлын хүрээнд зээлийн шинэ төрөл нэмэх, гадаад валютаар зээл олгох боломжийг бүрдүүлэхээс гадна суралцагчийн баталгаажсан мэдээллийг системд хөрвүүлэн оруулах процессыг сайжрууллаа.

Мэдээлэл нийлүүлэх явцад илэрсэн зөрүүтэй зээлдэгчийн мэдээллийг системээс гарган шалгаж, овог, нэр, регистр, сургалтын байгууллага зэрэг үндсэн өгөгдлийг засварлан, Зээлийн мэдээллийн санд дахин илгээж баталгаажуулсан.

Зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг системд гараар бүртгэн оруулах, Монголбанкны Зээлийн мэдээллийн системд үлдэгдлийг шинэчлэх, мөн эргэн төлөлтийн график үүсгэх боломжийг бүрдүүлэн ажилласан.

Ийнхүү нийт дотоодын 12,300, гадаадын 1,407 зээлдэгчийн мэдээллийг амжилттай нийлүүлж, мэдээллийн сангийн бүрэн бүтэн байдлыг сайжрууллаа.

Үүнээс гадна “И-Монгол Академи” УТҮГ-ын Мэдэгдэл хүргэх системийг ашиглан Монголбанканд зээлийн мэдээлэл нийлүүлсэн талаар иргэдэд мэдээлэл илгээж, гадаад зээлээр суралцаж төгссөн 875 иргэн, хөнгөлөлттэй зээлээр суралцаж төгссөн 22,103 иргэн, нийт 22,860 иргэнд давхардсан тоогоор мэдэгдлийг хүргэн ажилласан байна.

XI. Шил ажиллагааны систем

Төрийн нээлттэй мэдээллийн “Шил” ажиллагааны мэдээллийн систем (<https://shilen.gov.mn/>)–д тус сангийн ил тод байдлын тайланг хуулийн дагуу 5 чиглэлээр нэгтгэн, байгууллагын үйл ажиллагаанд хамаарах нийт 39 бүлэг мэдээллийг бүрэн оруулан ажилласан.

Тайлангийн биелэлт улирлаар өссөн үзүүлэлттэй гарч, I улиралд 51.15 хувь, II улиралд 56.81 хувь, III улиралд 63.96 хувийн үнэлгээ авч, тайлангийн гүйцэтгэл улирал бүр тогтмол ахисан дүнтэй байна.

Сангийн бүтэц, үйл ажиллагаа, хөтөлбөр, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг шинэчлэн боловсруулж **gov.mn** домайнд байршуулсан байгууллагын веб хуудсанд нийцүүлэн оруулж, “Шил” ажиллагааны мэдээллийн системд тайлан, статистик болон ил тод мэдээллийг хугацаанд нь байршуулан ажилласан.

Эдгээр арга хэмжээ нь ил тод байдал, тайлагналын чанарыг сайжруулж, олон нийтэд мэдээлэл хүргэх сувгийг өргөтгөн, үнэлгээний хувь өсөхөд эерэгээр нөлөөлсөн болно. IV улирлын үнэлгээ 80+ хувьтай байна гэдэг хүлээлттэй байна.

XII. Тоон гарын үсэг, цахим гэрээний системийг байгууллагад нэвтрүүлэх

Цахим шилжилтийг хэрэгжүүлэх, өмнө нь цаасаар гүйцэтгэдэг байсан зарим үйлчилгээг цахимжуулах зорилгын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр “Тридүм Э-Секьюрити” ХХК-тай гэрээ байгуулж, байгууллагын үйл ажиллагаанд тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлэв. Ингэснээр гэрээ байгуулах, баталгаажуулах үйл явцыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх нөхцөл бүрдсэн.

Үүний хүрээнд Цахим гэрээний системийг ашиглан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай “ДАН” системд холбогдох 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн **2025/437** дугаар гэрээг, мөн “ХУР” системийн холболтын **2025 оны 5 дугаар сарын 19-ний 2025/549** дугаар гэрээг тус тус байгуулан, холболтын ажлыг хэрэгжүүлж ажиллав.

Ийнхүү тоон гарын үсэг болон төрийн нэгдсэн системүүдтэй холболтыг албан ёсоор байгуулснаар байгууллагын дотоод үйл ажиллагаа, мэдээлэл солилцоо, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хурд, найдвартай байдал нэг түвшинд сайжирсан болно.

XIII. Санхүү, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийг чанаржуулах

Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээг төрийн сангийн журмын дагуу батлагдсан маягтаар гаргаж Боловсролын яамны Төрийн санд 2025 онд 11 удаа хүргүүлсэн байна.

Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, төсвийн дунд хугацааны төлөвлөлт буюу төсвийн хүрээний мэдэгдэлд саналыг дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

Хагас жилийн санхүүгийн тайлан гаргахтай холбоотой дараах тайлан мэдээг сар улирал, тухай бүр бэлтгэн, хянан баталгаажуулж байна.

- Сар бүр төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэсэн,
- Харилцах дансны хуулга боловсруулсан,
- Бараа материалын тайлан бэлтгэсэн,
- Үндсэн хөрөнгийн тайлан бэлтгэсэн,
- Авлагын тайлан бэлтгэсэн /арга хэмжээ бүрээр/,
- Мөнгөн хөрөнгийн тайлан бэлтгэсэн,
- Дотоодын их дээд сургуульд олгох санхүүжилтийн нэгтгэл тооцоо гаргасан,
- Гадаадад суралцагчдад олгох санхүүжилтийн тайланг арга хэмжээ бүрээр хөтлөн гаргасан,
- Цалин хөлс олгосон тайлан /нэгтгэл/ бэлтгэсэн
 - НДШ-ийн тайлан
 - ХХОАТ-ын тайлан
 - Зээлийн эргэн төлөлтийн тайлан /7 хоног бүр/
- УАГ-аас ирсэн хяналт шалгалтын ажлын хэсэгт тайлан мэдээ хүргэсэн.
- 2025 оны 06 сарын 30-ны өдрөөр тасалбар болгон эхний хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайланг холбогдох хууль, стандартын дагуу тайлагнаж, 2025 оны 1 дүгээр сарын 25-нд УАГ хүргүүлэхээр ажиллаж байна. 2024 оны аудитлагдсан тайланг хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тайлагнаж, 2026 оны 01 дүгээр сарын 25-нд УАГ-т хүргүүлэхээр ажиллаж байна.

Нийгмийн даатгалын системд шинээр орсон, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагч болон гэрээгээр ажиллаж байгаа албан хаагчийн мэдээллийг шинэчлэн оруулж, сар бүр тайланг хянаж баталгаажуулсан.

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг дээд шатны байгууллагад тухай бүр хүргүүлэн ажилласан.

XIV. Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийх

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2025 оны 3 дугаар улирлын тайлан мэдээ, мэдээллийг болон цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 92.3 тэрбум төгрөгийн 255 ширхэг орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 83.6 тэрбум төгрөгийн 674 ширхэг зарлагын мөнгөн гүйлгээг холбогдох анхан шатны баримт, материалыг хавсарган баталгаажуулан оруулсан.

- Батлагдсан төсөв жилээр: 157,866,661,000.00
- Батлагдсан төсөв тайлант үе /Өссөн дүнгээр/: 90,178,982,900.00
- Батлагдсан төсвийн гүйцэтгэл /Өссөн дүнгээр/: 57,518,941,795.10
- Хэтрэлт, хэмнэлт /Өссөн дүнгээр: 32,660,041,105.00

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээ, мэдээллийг 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 159 мэдээлэл оруулахаас хуулийн хугацаанд ил тод болгосон 141 мэдээлэл, хуулийн хугацаа болоогүй-18 мэдээлэл байна. Цаашид мэдээллийг үнэн зөвөөр олон нийтэд ил тод үнэн зөв байршуулахаар ажиллаж байна.

Санхүүгийн программд үндсэн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ, дотоод хөдөлгөөний гүйлгээг бүртгэж, хагас жил бүр үндсэн хөрөнгийн тайланг хянан баталгаажуулсан.

Санхүүгийн программд бараа материалын орлого, зарлагын гүйлгээг бүртгэж, сар бүр бараа материалын тайланг хянан баталгаажуулсан. 2025 оны А176 тоот тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинэчлэн байгуулж, жилийн эцсийн тооллогыг хийж байна.

ТӨБЗГ-руу хөрөнгө актлах албан бичиг хүргүүлсэн. Хөрөнгө худалдан авах зөвшөөрлийн албан бичгийг дээд шатны байгууллага руу явуулсан.

2024 оны жилийн эцсийн тооллогыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын программд шивж, тайланг илгээсэн.

Валютын харилцахын 201900015004 /usd/ тоот дансаар гарсан 46.3 тэрбум төгрөгийн гүйлгээг бүртгэн, хуулга боловсруулалтын ажлыг өдөр тутам хийж, хянасан.

Валютын харилцахын 202900015004 /evro/ тоот дансаар гарсан 8.2 тэрбум төгрөгийн гүйлгээг бүртгэн хуулга боловсруулалтын ажлыг өдөр тутамдаа хийж, хянасан.

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН АЖЛЫН АЛБА